



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2016 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 19

Мандалговь

Г Хөрөнгө данснаас хасах тухай Г

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сайнцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 15,000,000 /арван таван сая/ төгрөгийн анхны өртөгтэй, 2,083,333 /хоёр сая наян гурван мянга гурван зуун гучин гурав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Дуа 61-61 улсын дугаартай Nissan X-Trail маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 4,000,000 /дөрвөн сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дарьбумд үүрэг болгосугай.

Гурав. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Сайнцагаан сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтуяа даалгасугай.

ДАРГА  С.СҮХБААТАР